# ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:** "Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | | |
| 1.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах; | 10,5 сая | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн салбар зөвлөлтэй хамтран сарын аян зохион байгуулсан. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн салбар зөвлөлтэй хамтран 4, 5 дугаар сард аж ахуйн нэгжүүдэд хоёр удаагийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.<br>Дээрх сургалтын хүрээнд Нийгмийн даатгалын газрын зүгээс Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон даатгуулагч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хэрхэн авах талаар, мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулснаар ямар үйлчилгээг авах эрхтэй болох талаар оролцогчдод дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголтыг өгч ажиллав. Уг сургалтуудад 24 аж ахуйн нэгж байгууллагын 126 албан хаагч нар оролцсон. | *ЗХХ Ганхуяг Туул Цэрэнжаргал* |
| 1.4. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл | - | 2 удаагийн сэтгэл ханамжийн | | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн | Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж | *ЗХХ Туул* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| - | ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | | судалгаа хийгдсэн байна. - | - | сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. - | байгаа иргэд, даатгуулагчид болон тус газраас гадагшаа чиглэсэн мэдээлэл, сургалт өгсөн аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаанд нийт 105 иргэн хамрагдсанаас 26-55 насны иргэд 97 хувийг эзэлсэн байна.<br><br>Судалгаанд оролцогчдын 66.7 хувь нь нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг авах хүсэлтэй байгаа бол нийгмийн даатгалын үйлчилгээний талаар ихэвчлэн олон нийтийн сүлжээ буюу /Фэйсбүүк/ хуудсаар дамжуулан мэдээлэл авч байгаа дүн гарсан бөгөөд Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг гар утасны аппликэйшинг ашиглан авдаг иргэд 66.7 хувь нь байна. Цаашид нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрээр явуулбал даатгуулагч нарт илүү хүртээмжтэй хүрэхээр байгаа нэгдсэн дүн гарсан байна.<br><br>Энэ удаагийн сэтгэл ханамжийн судалгаанаас харахад даатгуулагчийн сэтгэл ханамж өмнөх оноос өссөн үзүүлэлттэй гарч байгаад талархалтай байгаа бөгөөд судалгааны дүгнэлтийн дагуу дараах зөвлөмжид хүрсэн. Үүнд: Зарим тохиолдолд тэтгэвэрт гарч байгаа иргэдээс шаардлагагүй баримт шаардах тохиолдол гарч байгаад анхаарах мөн дутуу мэдээлэл өгсний улмаас иргэд дахин ирэх цаг хугацаа алдаж байгаа дүгнэлт гарсан тул энэ 2 тал дээр цаашид анхаарч ажиллахаар шийдэлд хүрсэн байна. | *Цэрэн жаргал* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | - | Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 83 хувийн гүйцэтгэлтэй байна. | Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах зорилгоор хуульд заасан мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт хугацаанд нь бүрэн байршуулж ажиллав. Мөн байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитойгоор олон нийтэд хүргэж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдийн мэдээлэл авах эрхийг бүрэн хангаж ажилласан болно. Мэдээлэл байршуулалтын гүйцэтгэлээр 2025 оны 1 дүгээр улиралд 84 хувь, 2 дугаар улиралд 85 хувьд хүрсэн байна. | *ЗХХ Ганхуяг Наранбаяр* |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуулалтад хяналт тавих; | - | - Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна.<br>- Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 69 хувьтай байна.<br>- | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Шилэн дансны мэдээллийн нэгдсэн систем (shilendasn.gov.mn) цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тухайн жилийн батлагдсан төсөв, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, санхүүгийн тайлан, батлагдсан бүтэц, орон тооны өөрчлөлт, төсвийн төсөөлөл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний долоо хоног бүрийн санхүүжилтийн дүн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээ (гэрэл, цахилгаан, түлш, халаалт, нэр данс зөрүүтэй гүйлгээ, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, газрын даргын тушаалын дагуу олгосон бусад тусламж дэмжлэг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, сарын гүйлцэтгэлийн мэдээний дүн) зэрэг мэдээллийг PDF хэлбэрээр, өссөн дүнгээр сар болон долоо хоног бүр хуулийн | *ЗХХ Ганхуяг Бямбаа* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд нь байршуулан ажилласан.<br><br>Үүнд:<br><br>- Тухай бүрт оруулах 9 төрлийн мэдээллийг 6 удаа,<br>- Сар бүр оруулах 4 төрлийн мэдээллийг 6 удаа,<br>Хагас жилээр оруулах мэдээллийг холбогдох хугацаанд нь тус тус байршуулсан болно. | |
| ***Зорилт 3.1:*** *"Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | - | - Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь,<br>- Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн - тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь. | - | Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | Газрын дотоод хяналт шалгалтаар 2023-2024 онуудын 15121 тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн олголт, шилжилт хөдөлгөөн, нас баралтад шалгалт хийв. Шалгалтаар дутуу олгосон тэтгэвэр авагч 42 хүнд холбогдох 7,5 сая төгрөг, илүү олгосон 65 тэтгэвэр авагчтай холбогдох 22.1 сая төгрөгийн олголтыг илрүүлэн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулсан. Мөн тэтгэмж илүү тогтоолгон авсан 3 иргэнд 3,5 сая төгрөгийн Улсын байцаагчийн акт тогтоож бүрэн барагдуулсан. | *ЗХХ Цэрэн жаргал , Туул* |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, | - | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц | Их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийв. Шалгалтаар "Түгээмэл оюу", "Фловер", "Долоодой" сургуулиудын санхүүгийн баримт материалд тулгуурлан 2020-2024 оны хугацааны нийгмийн | *ЗХХ Цэрэн жаргал Туул* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | | шалгасан байна. | | хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | даатгалын хамрагдалтыг хянан шалгалаа.<br><br>Шалгалтын үр дүнд:<br><br>"Түгээмэл оюу", "Долоодой" сургуулиуд үндсэн болон гэрээт, цагийн ажилчдаа Нийгмийн даатгалд бүрэн хамруулан ажиллаж байгаа нь тогтоогдсон. "Фловер" сургууль нь 6 өндөр настан иргэнийг нийгмийн даатгалд хамруулаагүй зөрчил илэрсэн.<br><br>Иймд Зөрчлийн тухай хуулийн дагуу "Фловер" сургуульд 2,1 сая төгрөгийн нөхөн төлбөр, 200,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Мөн "Түгээмэл оюу" сургуульд 4,7 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулан ажиллалаа. | |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | -<br><br>Шалгалтын хуваарийн дагуу 3, 4 улиралд шалгана. | *ЗХХ Цэрэнжаргал, Туул* |
| 3.1.4. | Ажилгүйдлийн | Батлагдсан | -Шалгалт хийсэн | - | Ажилгүйдлийн | Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан | ЗХХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;<br>- | төсвийн хүрээнд | объектын гүйцэтгэлийн хувь<br>-Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | - | даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 60-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна. | сэргийлэх хяналт, шалгалт хийв. Шалгалтаар нэр бүхий 21 иргэнд илүү олгосон 25,3 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын санд нөхөн төлүүлэхээр, харин 3 иргэнд дутуу олгосон 3,1 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас нөхөн олгохоор улсын байцаагчийн акт тогтоосон.<br><br>Мөн шалгалтын явцад 1,5 сая төгрөгийг 3 иргэнд нөхөн олгуулсан. Байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүссэн 2 аж ахуйн нэгжийн 2 иргэний 6.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгоогүй, өглөг үүсгэсэн байна.<br><br>Илүү олголт үүссэн шалтгаан нь ажилд орсон даатгуулагч нар ажилд орсон тухайгаа мэдэгдээгүй, тушаал шийдвэрийг нийгмийн даатгалын байгууллагад ирүүлээгүй, мөн Дорнод аймгаас өөр газар (Улаанбаатар болон орон нутагт) ажилд орсон тохиолдолд тэтгэмж олгосон хоногийн зөрүүгээс илүү олголт үүссэн байна.<br><br>Ажилгүйдлийн даатгалын сангийн 2023, 2024 оны нийт 733 олголтыг нэг бүрчлэн тулгаж шалгасан бөгөөд 2022-2023 оны олголтыг түүвэрлэн 70 хувьд нь хяналт, шалгалт хийсэн болно. | Цэрэн жаргал Туул<br>- |
| 3.1.5. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Удирдамжийн хугацаанд мэдээ | 2024 онд 31 объектод хяналт шалгалт хийж, 20 зөрчил илрүүлж, 6 албан шаардлага хүргүүлж, 19 зөрчлийн хэрэг бүртгэл хийж ажилласан. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан, их болон дунд эрсдэлтэйгээр үнэлэгдсэн 18 аж ахуйн нэгжээс 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоосон бөгөөд 8 байгууллага хяналт, шалгалтад хамрагдсан байна. Шалгалтын явцад дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд: | *ЗХХ Цэрэн жаргал* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | | | -Ажилчдын ажилласан жилийг буруу тооцсон;<br><br>-Хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилчдын код, нэршлийг буруу бичсэн;-<br><br>-Байгууллагын дотоод хяналт, шалгалтын тогтолцоо бүрэн ажилладаггүй;<br><br>-Хөдөлмөрийн баталгаа (ХБ) авч ажиллуулаагүй;<br>-Цэргийн алба хаасан хугацаа болон нөхөн даатгалтай иргэдийн ажилласан жилийг тооцоогүй;<br>-Ахмадын сан байгуулаагүй;<br>-Өр үүссэн зэрэг зөрчил дутагдал илэрсэн.<br><br>Илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулж, холбогдох байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан болно. | |
| 3.1.6. | - Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | - | - - Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,<br>- НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо, | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан. | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Зөрчил арилгуулах тухай” Улсын ахлах байцаагчийн албан шаардлагын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>-<br>Шалгалтаар тэтгэвэр, тэтгэмжийг 7 хүнд дутуу олгосон 1.5 сая төгрөгийг бүрэн нөхөн олгосон.<br><br>Тэтгэвэр, тэтгэмжийг 12 хүнд илүү олгосон 28.0 сая төгрөгөөс 9 хүний 6.0 сая төгрөгийг бүрэн барагдуулж, 3 хүний 22.0 сая төгрөгийн барагдуулалтыг шүүхийн байгууллагад шилжүүлэн ажиллаж байна. Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд гарган, Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн болно. | *ЗХХ Туул, Цэрэнжаргал ТТХ* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах, | Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд зөрчлийн шинжтэй 65 гомдол, мэдээллийг хүлээн авч, хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулан, байгууллага болон иргэний зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэв.<br><br>Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 59 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд нийт 15.1 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчлийг 100 хувь бүрэн барагдуулсан.<br><br>Хяналт шалгалтын хагас жилийн тайланг хуулийн хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн болно. | *ЗХХ Ганхуяг, Цэрэнжаргал Туул* |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | - | - 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.<br>-Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн | 2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, - биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна. | Чулуунцэцэг<br>- | *ЗХХ Цэрэнжаргал, Туул, Чулуунцэцэг* |
| 4.2. | Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг | - | -Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ.<br>-Өргөдөл | 2024 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98 хувь | Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, | 2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, даатгуулагчаас 18 өргөдөл ирүүлсний 77,7% буюу 14 өргөдлийг шийдвэрлэж, хариуг утсаар болон биечлэн мэдэгдэж, холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. | *ЗХХ Цэрэнжаргал, Туул, Чулуунцэцэг* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | | шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна. | | |
| 4.3. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх; | - | Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангаж ажилласан. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргах, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр тайлагнасан байна. | Нийгмийн даатгалын газрын зүгээс батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, сул орон тоог холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарлан ажиллалаа. Энэ ажлын хүрээнд 2025 оны 1-р улирлын байдлаар Булган сумын нийгмийн даатгалын байцаагч, сайн дурын даатгалын байцаагчийн сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар бүтэц, орон тоог 100 хувь бүрэн нөхсөн байна. | ЗХХ Ганхуяг, Чулуунцэцэг |
| 4.4. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх; | - | Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. - | Цаг хугацаанд нь үнэн зөв гаргах. | Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Аймгийн нийгмийн даатгалын газраас 2025 оны 1 дүгээр сард мэргэшлийн зэрэг ахиулах болон шинээр авах албан хаагчдын судалгааг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж, 9 албан хаагч "Итгэмжит зөвлөх" зэрэг ахиж, 1 албан хаагч шинээр "Зөвлөх" зэргийн нэмэгдлийг авч эхэлсэн. | ЗХХ Чулуунцэцэг |
| 4.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлсэн. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны дэд төлөвлөгөөг баталж, газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөө тайлагнах загвар шинэчлэгдэж гарсны дагуу биелэлтийг хугацаанд нь гаргаж аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажилласан. | ЗХХ Ганхуяг Чулуунцэцэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.6. | Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | - | Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна. | Салбарын хэмжээнд 100 хувь ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж холбогдох газарт хүргүүлсэн. | Авлигын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Тус газрын 22 албан хаагчдын 2024 оны хувийн ашиг сонирхлын хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргасныг хянан баталгаажуулж, www.meduuleg.iaac.mn системээс үүссэн ХАСХОМ 1, 3, 4, ХОМ хураангүй тайланг газрын даргаар баталгаажуулан хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэн ажилласан.<br><br>Тайлант хугацаанд ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэг өөрчлөгдсөн 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй ажиллаж байна. | *С.Бямбаа* |
| 4.7. | 2024 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх; | - | Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна. | - | Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ. | Бахйгүй | *ЗХХ Ганхуяг, Туул, Цэрэнжаргал* |
| 4.8. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | - | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байсан. | Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар харигутай буюу хугацаатай 70 албан бичиг ирснийг 100% цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. | *ЗХХГанхуяг, Цэрэнжаргал, Туул, Чулуунцэцэг* |

***Зорилт 4.1:** “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах”* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Аймгийн нийгмийн даатгалын газраас авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу доорх ажлыг хийж гүйцэтгэв.<br>Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, постер, зурагт хуудасыг байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл сурталчилгааны самбарт байршуулан ажил олгогч, даатгуулагчдад сурталчилан ажилласан.<br>Авлигатай тэмцэх газраас авлига ашиг сонирхоос урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулж буй танхимын /1/ болон цахим /2/ сургалтад эрх бүхий албан тушаалтан болон нийт албан хаагчдыг тогтмол хамруулж байна. | *ЗХХ Ганхуяг, Цэрэнжаргал Туул* |
| 4.1.2. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | - | - Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>-Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 55 удаагийн сургалтад албан хаагчдийг танхим болон цахимаар 100% хамруулсан. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын газрын албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.<br>-“Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам” цахим сургалтад 6 албан хаагчийг хамруулсан.<br>-“Багшлахуй” захиалгат сургалт, сургагч багшийн чиглэлээр танхимын сургалтад 3 албан хаагчийг хамруулсан.<br>-Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж буй “5 дахь өдрийн” цахим сургалтад газрын албан хаагчдыг тогтмол | -<br>*ЗХХ Ганхуяг, Чулуунцэцэг* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцуулж хэвшсэн.<br><br>- Төрийн өмчийн газраас “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын нэгдсэн систем” сэдвээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтад 6 албан хаагч оролцов. | |
| 4.1.3. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;<br>- | - | -Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>- 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах,<br>-Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.<br>- | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 78 удаагийн сургалтад нийт 6080 иргэд, даатгуулагч, үүнээс 23 аж ахуйн нэгжийн 523 даатгуулагч, ажил олгогчийг хамруулсан. | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.<br>- | Аймгийн Засаг даргын 2025 оны А/183 дугаар захирамжийн дагуу Нийгмийн даатгалын газраас алслагдсан сум, багийн иргэдэд “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-г амжилттай зохион байгууллаа. Энэ хүрээнд Матад, Халхгол, Цагаан-Овоо, Баян-Уул, Баян-Дун, Сэргэлэн, Чулуунхороот сумдын иргэд хамрагдсан юм. Үйлчилгээний үр дүнд төрийн болон нийгмийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх боломж бүрдсэн. Ийнхүү алслагдсан бүсийн иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулаа.<br><br>Үйлчилгээний явцад иргэдэд нийгмийн даатгалын хууль, түүний ач холбогдол, цахим үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, сонирхсон асуултад газар дээр нь хариулт өгсөн.<br><br>Мөн сум, багийн удирдлагуудтай уулзалт хийж, сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах талаар санал солилцов. Энэ үйл ажиллагаа нь нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд мэдээлэл, үйлчилгээг ойртуулсан чухал алхам боллоо.<br><br>Уг ажлын хүрээнд тухайн сумдын Засаг даргын Тамгын газар, Хилийн цэргийн 198 дугаар анги, Зэвсэгт хүчний 329 дүгээр анги, Онцгой байдлын ангиуд, сургууль, цэцэрлэг, | *ЗХХ Ганхуяг, Цэрэнжаргал, Туул* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүл мэндийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид болон нийт 111111 иргэд хамрагдлаа. | |
| ***Зорилт 4.2:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан. | Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | Нийгмийн даатгалын газрын ажлын байр, үйлчилгээний орчны стандартын дагуу байгууллагын гадаад дотоод орчны стандарт ажлын байрны ерөнхий стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:<br>-Төв хаалганы хаягийг "Нийгмийн даатгалын байгууллагын хаягийн нэгдсэн стандарт"-ын дагуу байршуулсан<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох зориулалттай тусгай налуу гарцтай.<br>-Хатуу хучилттай талбай бүхий тээврийн хэрэгслийн зогсоолтой.<br>-Зориулалтын хогийн сав байршуулсан.<br>-Ногоон байгууламж байгуулсан.<br>-Мэдээллийн самбар нь ажилтнуудын мэдээллийг бүрэн байршуулсан.<br>-Ажлын байрны гэрэлтүүлгийг сайжруулан лед болон сүүн гэрэл тавьсан.<br>-Цахилгааны утас, залгуур, сүлжээний кабель утасны аюулгүй байдлыг хянаж ажиллаж байна.<br>-Цагийн бүртгэлийг "Able"-ээр бүртгэснээр ажлын цаг ашиглалт дээшилсэн.<br>-Үүдний хэсэгт угтах үйлчилгээний ажилтны ашиглах ширээ, сандал, компьютер,<br>- Call pro үйлчилгээний утас ажиллуулж иргэд даатгуулагчдаас санал хүсэлт хүлээн авч асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.<br>-Аюулгүй байдал болон үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор дуу, | *ЗХХ Ганхуяг, Чулуунцэцэг* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - | | - | | - | дүрсийг бичих боломжтой хяналтын камерыг үйлчилгээний танхим болон угтах үйлчилгээний хэсэгт байрлуулсан.<br>-Галын аюулгүй ажиллагааны заавар, журмын дагуу аюулгүй гарцны бүдүүвч зураг, газ байршуулсан,<br>-Ариун цэврийн өрөөг үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй ашиглах боломжоор хангаж нээлттэй байлгадаг,<br>-Үйлчилгээний танхим болон бусад өрөөнүүдэд үйлчлүүлэгчдийг сандлын хүрэлцээг нэмэгдүүлсэн,<br>-Хүлээлгийн танхимд 4-өөс доошгүй хүний суух сандал, угтвар ширээг байршуулсан,<br>- Сургалтын танхим болон ажилтнуудын амрах чөлөөт цагийн өрөөг тохижуулсан.<br>- Архивын хадгаламжийн нэгжийг төрөл тус бүрээр нь өнгөөр ялган хаягжуулсан,<br>- Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг тэтгэврийн төрөл, дугаараар эрэмблэн зориулалтын сейфэнд хадгалдаг.<br>Байцаагч ажилтнууд нь албан тушаалын тодорхойлтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг баримтлан ажлын цаг ашиглалтыг сайжруулж, харилцаа хандлагадаа анхаарч ажиллаж байна. | |
| 4.2.2. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | Ирсэн дуудлага 4978, дуудлага алдалт дунджаар 26 %. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. | Наранбаяраас нэг программаас авдаг гэсэн яаахуу | *ЗХХ Чулуунцэцэг* |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл | - | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг<br>-"Рийл" улиралд 3-аас доошгүй | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан | Орон нутгийн иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, хуулийн шинэчилсэн найруулга, цахим үйлчилгээ болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэх зорилгоор 14 хоног тутам хэвлэгддэг "Дорнод" сонинд нийт 5 удаагийн | *ЗХХ Ганхуяг, Наранбаяр* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| - | мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | - | удаа;<br>-“Постер” сард 3-аас доошгүй удаа;<br>-“Видео контент” улиралд 1 удаа;<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа; | мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан. | сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.<br>- | дугаарт мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлсэн.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын газрын албан ёсны фейсбүүк хуудас (пейж)–д нийт 116 мэдээлэл байршуулсан байна. Үүнд:<br>• Нийгмийн даатгалын ерөнхий газрын пейжээс хуваалцсан мэдээ – 12<br>• Reel бичлэг – 12<br>• Зурагт постер – 75<br>• Видео пост – 3<br>• Мэдээ, мэдээлэл – 13<br>• Cover зураг – 1<br><br>Бэлтгэсэн мэдээллийг олон нийтэд хүргэх, хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн пейж хуудаснаас гадна ажил олгогчид, сайн дурын даатгуулагчид болон сум бүрийн нийгмийн даатгалын байцаагчдын фейсбүүк хуудсуудыг идэвхтэй ашиглан мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлж, дагагчдын тоог нэмэгдүүлэн ажиллаж байна. Ингэснээр мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэх, санал хүсэлт, асуултад цаг тухайд нь хариу өгөх боломжийг бүрдүүлж байна. | |
| ***Зорилт 4.5:*** *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.5.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан | Газрын хэмжээнд ашиглагдаж буй программ хангамжуудын өдөр тутмын хэвийн ажиллагаанд хяналт тавьж, алдаа гарсан үед дээд шатны байгуулагатай холбогдон засаж, ажиллагааг хэвийн болгон ажилласан.<br>Мэдээллийн нэгдсэн “core” системд /Sicos/ шилжсэнтэй холбоотойгоор бүх байцаагч, ажилтнуудыг чадавхжуулахаас гадна 2 байцаагчийг танхимын сургалтанд хамруулж | *ЗХХ Ганхуяг, НАран баяр* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | сургагч багшаар бэлтгэв. Ингэснээр программын хэрэглээг бүрэн ашиглаж | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин / биелэлт/ |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 6 |
| 1. | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна.<br>-Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдан суралцаж байна. |
| 2. | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах;<br>- | Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана. | - | Нийгмийн даатгалын ерөнхий газрын захиалгаар МУБИС-ийн боловсрол судлалын сургуульд “Сургагч багш” бэлтгэх захилгат 2 кредитийн сургалтад хамрагдсан. |
| | | | - | |

ТАЙЛАНГ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАНХУЯГ

ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА Д.АРИУНБОЛД